



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/120

Шивээговь сум

Шүдний кабинет ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай" 322 дугаар тогтоол, Аймгийн эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний "2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний 3 дугаар зорилт 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, эмчлэх зорилгоор Сумын эрүүл мэндийн төвд шүдний кабинетийг 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулсугай

2. "Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд амны хөндийн эрүүл ахуй, шүдний эмчилгээ, үйлчилгээний эрүүл мэндийн тусламжийг өөрийн орон нутаг, сумын түвшинд хэрэгжүүлэн ажиллах боломжийг бүрдүүлэн, хэрэгцээт тоног төхөөрөмж, зардлыг шийдвэрлэн ажиллахыг Сумын эрүүл мэндийн төвийн дарга (П.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА